



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2020.07 сар













bayanzurkh@nso.mn



page: Баянзүрх дүүргийн
статистикийн хэлтэс

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ	5
 ЭРҮҮЛ МЭНД	7
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	13
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	16
 АЖ ҮЙЛДВЭР	19

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлт, жил бүрийн эхний VII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020
Суурин хүн ам	мянган хүн	327.1 ^{↑1.9}	336.9 ^{↑3.0}	*343.6 ^{↑2.0}	*361.5 ^{↑5.2}
Нийт өрхийн тоо	мянган өрх	93.7 ^{↑0.6}	95.0 ^{↑1.4}	*96.0 ^{↑1.1}	*104.7 ^{↑9.0}
Шинээр төрсөн хүүхэд	тоо	4 356 ^{↓7.9}	4 514 ^{↑3.6}	4 561 ^{↑1.04}	4 608 ^{↑1.03}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	4 920 ^{↓40.7}	3 475 ^{↓29.3}	4 113 ^{↑18.4}	2 086 ^{↓49.3}
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	2 503 ^{↓5.7}	4 855 ^{↑93.9}	3 567 ^{↓26.5}	2 835 ^{↓20.4}
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	-0.1 ^{↑120}	0.7 ^{↓800}	-0.1 ^{↓114.3}	0.7 ^{↓800}
Валютын зах зээлийн ханш	1 US\$=Төгрөг	2 444 ^{↑17.8}	2 456 ^{↑0.4}	2 672 ^{↑8.8}	2 832 ^{↑6.0}
Дүүргийн төсвийн орлого	тэрбум төгрөг	10.1 ^{↓79.3}	61.3 ^{↑506.9}	70.9 ^{↑15.7}	105.9 ^{↑49.4}
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	47.2 ^{↑5.3}	47.2 ^{↑5.3}	64.6 ^{↑36.9}	101.8 ^{↑57.6}

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан

↑, ↓ эерэг өөрчлөлтийн хувь;
 ↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
 = тогтвортой

* 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүн ам, өрхийн тоо

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2019 оны VII сард					2020 оны VII сард				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	310	Баянгол	7 779	Налайх	55	316	Баянгол	7 726	Налайх	55
			Чингэлтэй	1 780	Багануур	48		Чингэлтэй	1 711	Багануур	46
			Сүхбаатар	703	Багахангай	32		Сүхбаатар	703	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	81	Багахангай	637	Хан-Уул	59	49	Багахангай	601	Баянзүрх	44
			Багануур	147	Баянгол	56		Багануур	173	Чингэлтэй	38
			Баянзүрх	120	Сонгинохайрхан	40		Баянгол	73	Сонгинохайрхан	27
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Налайх	17	Сүхбаатар	8	11	Сонгинохайрхан	13	Хан-Уул	6
			Багануур	12	Хан-Уул	7		Налайх	12	Сүхбаатар	4
			Чингэлтэй	12	Багахангай	-		Чингэлтэй	9	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	102	Баянзүрх	121	Баянгол	78	68	Налайх	66	Сүхбаатар	40
			Сонгинохайрхан	85	Налайх	70		Багануур	62	Хан-Уул	37
			Хан-Уул	83	Багахангай	9		Сонгинохайрхан	62	Багахангай	16
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	76	Сүхбаатар	83	Налайх	13	66	Чингэлтэй	60	Багануур	10
			Чингэлтэй	60	Багануур	11		Сүхбаатар	56	Налайх	9
			Хан-Уул	52	Багахангай	7		Хан-Уул	40	Багахангай	7
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	144	Сүхбаатар	219	Налайх	92	105	Сүхбаатар	172	Сонгинохайрхан	72
			Чингэлтэй	159	Багануур	59		Баянзүрх	118	Багахангай	61
			Баянзүрх	159	Багахангай	42		Чингэлтэй	113	Багануур	50

Тайлбар: * - промилль ** - продицми



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2020 оны 7 дугаар сард 728 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1589 хүнээр (68.6%) буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 370 (50.8%) нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2018 VII	2019 VII	2020 VII	2018 VII	2019 VII	2020 VII
Ажилгүйчүүд, бүгд	2 055	2 317	728	100.0	100.0	100.0
Үүнээс: Магистр, доктор	13	15	3	0.8	0.6	0.4
Дипломын болон бакалавр	827	1 113	137	41.3	48.0	18.8
Тусгай мэргэжлийн дунд	69	63	17	3.6	2.7	2.4
Техникийн болон мэргэжлийн	37	45	18	2.1	1.9	2.5
Бүрэн дунд боловсролтой	1 056	1 044	540	49.6	45.0	74.2
Суурь боловсролтой	25	23	3	1.6	1.0	0.4
Бага боловсролтой	13	4	1	0.5	0.3	0.1
Боловсролгүй	15	10	9	0.5	0.5	1.2

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэдээлэл

Хөдөлмөрийн хэлтэст 7 дугаар сард 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгүүлсэн бөгөөд эдгээрийн 4 нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Бүртгэлтэй ажилгүйчүүд, насны бүлэг, 2020 оны VII сарын эцэст





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн орлого 79.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 25.6 тэрбум төгрөгөөр (24.5 %) буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын 64.3 хувийг тэтгэврийн даатгалын сангийн, 19.8 хувийг эрүүл мэндийн даатгал, 8.1 хувийг тэтгэмжийн даатгал, 6.2 хувийг ҮОМШӨ¹-ний даатгал, 1.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая төгрөг

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII	Зөрүү	Өсөлт, бууралт	Дүнд эзлэх хувь
Нийгмийн даатгалын сангийн дүн	104.7	79.1	25.6	-24.5	100.0
Тэтгэврийн даатгалын сан	67.7	50.9	16.8	-24.8	64.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн сан	20.2	15.7	4.5	-22.3	19.8
Тэтгэмжийн даатгалын сан	8.6	6.4	2.2	-25.6	8.1
ҮОМШӨ-ний даатгалын сан	6.6	4.9	1.7	-25.7	6.2
Ажилгүйдлийн даатгалын сан	1.6	1.2	0.4	-25.0	1.6

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөгөө 2020 I-VII	Гүйцэтгэл 2020 I-VII	Хэтрэлт (+) Хэмнэлт (-)
Нийгмийн даатгалын сангийн дүн	153.5	142.0	-11.5
Тэтгэврийн даатгалын сан	137.9	127.4	-10.5
Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	8.4	7.5	-0.9
ҮОМШӨ-ний даатгалын сан	1.3	1.2	0.1
Ажилгүйдлийн даатгалын сан	5.9	5.9	-

Эх үүсвэр: Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл

2020 оны эхний 07-р сард нийгмийн даатгалын сангийн зарлага 153.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс 11.5 тэрбум төгрөгөөр дутуу буюу 142.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

¹ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, эзлэх хувь, төрлөөр



Нийгмийн халамж: 2020 оны 7 дугаар сард нийгмийн халамжийн сангийн нийт зарлагын 54.2 хувь нь халамжийн тэтгэврийн санд, 14.7 хувь нь нөхцөлт мөнгөн тусламжид, 4.1 хувь нь ахмад настны хөнгөлөлтөд, 4.5 хувь нь жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжид, 1.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, 0.4 хувь нь алдарт эхийн одон, 2.5 хувь нь алдар цолтон ахмад настнуудад олгосон тусламж, хөнгөлөлт, 14.3 хувь нь хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал, амьжиргааг дэмжих зөвлөлд, 4.1 хувь нь насны хишгийн зардалд тус тус зарцуулагдсан байна.

Хүснэгт 6. Нийгмийн халамжийн орлого, зарцуулалт

Үзүүлэлт	Хүний тоо			Мөнгөн дүн, сая төгрөг		
	2018 VII	2019 VII	2020 VII	2018 VII	2019 VII	2020 VII
Халамжийн сангийн орлого	31 000	32 000	30 000	1 900.0	2 100.0	2 400.0
Зарлагын нийт дүн	37 670	41 604	28 606	2 042.3	2 694.5	2 368.4
Халамжийн тэтгэвэр	4 283	4 475	4 515	663.3	772.8	1 282.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	3 558	4 011	3 824	244.9	295.3	347.9
Ахмад настны хөнгөлөлт	1 509	1 571	630	265.1	236.4	97.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэмж	598	467	489	45.4	32.2	29.8
Жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж	3 081	2 338	2 779	119.2	88.0	107.2
Алдарт эхийн одонгийн тусламж	248	225	80	26.3	23.4	8.6
Алдар цолтон ахмад настнуудад олгосон тусламж, хөнгөлөлт	354	361	377	56.6	57.3	59.5
Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	19 179	15 832	14 603	227.3	183.5	339.1
Амьжиргааг дэмжих зөвлөл	-	-	-	-	-	-
Насны хишгийн зардал	4 860	12 324	1 309	394.2	1 005.5	96.2

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэдээлэл



ЭРҮҮЛ МЭНД


2020 онд 7 сард дүүргийн эмнэлэгт 4608 хүүхэд төрсөн нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 47 хүүхдээр (1.0%) өссөн үзүүлэлттэй байна. Нас баралт 759 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14 хүнээр (1.8%) буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 2086 болж өмнөх оны мөн үеэс 2027 хүнээр (49.3%) буурсан байна.

Зураг 3. Халдварт өвчин, 10000 хүнд ногдох



Зураг 4. Бэлгийн замын халдварт өвчний тоо



Хүснэгт 6. Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, жил бүрийн эхний VI сар

Үзүүлэлт	2016 VII	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII
Шинээр төрсөн хүүхэд	4 731	4 356	4 514	4 561	4 608
Эхийн эндэгдэл	4	1	2	-	3
100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	84.5	23.0	44.3	-	65.1
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	85	56	40	52	38
Амьд төрсөн 1 000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	18.0	12.9	8.9	11.4	8.2
1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	16	7	4	9	4
Амьд төрсөн 1 000 хүүхэд тутмаас 5 хүртэл насанд эндсэн хүүхэд	3.4	1.6	0.9	2.0	0.9
Нас баралт	775	723	813	773	759
Халдварт өвчнөөр өвчлөгчид	8 299	4 920	3 475	4 113	2 086
10 000 хүн ам тутамд ногдох халдварт өвчин	263.7	151.9	104.7	120.9	59.2

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2019 оны 7 сард 10000 хүн амд ногдох халдварт өвчний тоо 120.9 байсан бол энэ онд 59.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 61.7 хувиар буурсан байна. Бэлгийн замын халдварт өвчин 2020 оны 7 сард тэмбүү 410, заг хүйтэн 97, трихомониаз 231 тус тус бүртгэгдсэн.

Хүснэгт 7. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жилээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	4 920	3 475	4 113	2 086
	10000 хүнд	151.9	104.7	120.9	59.2
Үүнээс:					
Вируст гепатит	бодит тоо	54	35	31	24
	10000 хүнд	1.7	1.1	0.9	0.7
Менингит	бодит тоо	1	1	5	0
	10000 хүнд	0.03	0.03	0.1	0.0
Цусан суулга	бодит тоо	349	658	683	279
	10000 хүнд	10.8	19.8	20.1	7.9
Салхин цэцэг	бодит тоо	1634	1036	1 612	397
	10000 хүнд	50.4	31.2	47.4	11.3
Гахай хавдар	бодит тоо	23	41	6	3
	10000 хүнд	0.7	1.2	0.2	0.1
Сальмонеллөз	бодит тоо	23	95	42	32
	10000 хүнд	0.7	2.9	1.2	0.9
Улаан эсэргэнэ	бодит тоо	380	177	147	35
	10000 хүнд	11.7	5.3	4.3	1.0
Хоолны хордлого	бодит тоо	24	31	144	14
	10000 хүнд	.0.7	0.9	4.2	0.4
Ёлом	бодит тоо	30	10	19	11
	10000 хүнд	0.5	0.3	0.6	0.3
Бруцеллөз	бодит тоо	7	2	3	5
	10000 хүнд	0.2	0.1	0.1	0.1
Нярайн халдвар	бодит тоо	0	0	1	0
	10000 хүнд	0.0	0.0	0.03	0.0
Гар хөл амны өвчин	бодит тоо	1113	410	328	62
	10000 хүнд	34.4	12.3	9.6	1.8
Тэмбүү	бодит тоо	295	327	310	410
	10000 хүнд	9.1	9.8	9.1	11.6
Заг хүйтэн	бодит тоо	116	123	116	97
	10000 хүнд	3.6	3.7	3.4	2.8
Трихомониаз	бодит тоо	215	213	264	231
	10000 хүнд	6.6	6.4	7.8	6.6
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	361	303	378	384
	10000 хүнд	11.1	9.1	11.1	10.9
Бусад	бодит тоо	295	13	24	102

Эх үүсвэр: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын сар бүрийн мэдээлэл



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2020 оны 7 дугаар сард дунджаар 18.6⁰C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.7⁰C-аар сэрүүн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 33.4⁰C, хамгийн хүйтэн хэм 6.4⁰C, хур тунадасны нийлбэр 92.3 мм, шороон болон цасан шуургатай өдөр бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 8. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, VII сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Ургах наран хороолол	Офицеруудын ордон	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.003	0.001	-
	Хамгийн их	0.017	0.004	-
	XXX* -с давсан хувь	0.0	0.0	-
	Хэмжилтийн тоо	31	25	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.008	0.013	0.021
	Хамгийн их	0.015	0.024	0.030
	XXX* -с давсан хувь	0.0	0.0	0.0
	Хэмжилтийн тоо	29	25	30
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.451	-	-
	Хамгийн их	1.239	-	-
	XXX* -с давсан хувь	0.0	-	-
	Хэмжилтийн тоо	86	-	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.045	-	0.040
	Хамгийн их	0.157	-	0.084
	XXX* -с давсан хувь	3.0	-	0.0
	Хэмжилтийн тоо	31	-	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	-	0.012
	Хамгийн их	-	-	0.025
	XXX* -с давсан хувь	-	-	0.0
	Хэмжилтийн тоо	-	-	31
Озон O ₃ **	Дундаж	0.038	-	-
	Хамгийн их	0.082	-	-
	XXX* -с давсан хувь	0.0	-	-
	Хэмжилтийн тоо	93	-	-

* - Хүлцэх хэм хэмжээ,

** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.



ГЭМТ ХЭРЭГ


2020 оны 7 сард дүүргийн нутаг дэвсгэрт 2 835 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 732 хэргээр (20.5%) буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, эхний 6 сард

Төрөл	2019	2020	Үүнээс: Цагдаагийн хэлтсээр			Өсөлт, бууралт	
			I	II	III	Тоо	Хувь
Нийт	3 567	2 835	1 131	991	713	-732	-20.5
Үүнээс:							
Учрал	48	29	12	7	10	-19	-39.6
Хүний амь	12	17	6	3	8	5	41.7
Хүчин	52	32	9	9	14	-20	-38.5
Дээрэм	157	74	25	41	8	-83	-52.9
Өмчийн хулгай	1 192	956	472	239	245	-236	-19.8
Булаалт	-	-	-	-	-	-	-
Залилан	704	661	191	379	91	-43	-6.1
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	936	779	279	229	271	-157	-16.8
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	91	57	18	23	16	-34	-37.4
Танхайрах	-	1	1	-	-	1	100
Бусад	375	229	118	61	50	-146	-38.9

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33.7 хувийг өмчийн хулгайн гэмт хэрэг эзэлж байгаа бол 27.5 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 23.3 хувийг залилан, 2.6 хувийг дээрэм, 2.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, 1.0 хувийг золгүй учрал, ашиглалтын журмын эсрэг хэрэг 8.1 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Зураг 5. Бүртгэгдсэн гэмт хэрэг, илрүүлэлт, дүүргээр



Хүснэгт 10. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2019-2020	
	2018 VII	2019 VII	2020 VII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	16 118	13 562	10 278	-3 284	-24.2
Баянзүрх	4 855	3 567	2 835	-732	-20.5
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр					
I хэлтэс	1 640	1 284	1 131	-153	-11.9
II хэлтэс	2 233	1 418	991	-427	-30.1
III хэлтэс	982	685	713	28	4.1
Нийслэлийн дүнд эзлэх хувь	30.1	26.3	27.6	1.3	4.9

Дүүргийн хэмжээнд 2020 оны 7 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувийн жин 27.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр нэмэгдсэн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 39.9 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

Хүснэгт 11. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:		Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон		
Нийслэлийн дүн	8 976	3 655		40.7
Баянзүрх	2 301	885		38.5
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр				
I хэлтэс	1 016	340		33.5
II хэлтэс	724	336		46.4
III хэлтэс	561	209		37.3
Нийслэлийн дүнд эзлэх хувь	25.6	24.2		0.9

Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 38.5 байгаа нь нийслэлийн дунджаас 2.2 пунктээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 827 хүн гэмтэж осолдон, 58 хүн нас барж, төр ард иргэдэд 13 195.8 сая төгрөгийн хохирол учруулсны 3 558.8 сая (26.9%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2020 оны 7 сард тус дүүргийн хамгийн их хүн ам суурьшсан бүс болох 14 дүгээр хороонд 313 гэмт хэрэг гарч хамгийн өндөр байхад харин тус дүүргээс 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт 29 гэмт хэрэг гарсан нь хамгийн бага байна.

Эх үүсвэр: Цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн сар бүрийн мэдээлэл




ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2020 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр дүүргийн төсвийн орлого 105.9 тэрбум төгрөг, төсвийн зарлага 101.8 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 4.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Хүснэгт 12. Дүүргийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 7 сард


Үзүүлэлт	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII
	сая төгрөг			
Төсвийн орлого	51 026.6	61 345.2	70 916.3	105 889.1
Төсвийн зарлага	47 254.6	54 927.9	64 643.5	101 793.1
Төсвийн орлого, зарлагын зөрүү	3 772.0	6 417.3	6 272.8	4 096.0

Зураг 6. Төсвийн нийт орлого, зарлага, сая төгрөг



Төсвийн орлого: 2020 оны эхний 7 сарын төсвийн гүйцэтгэлийн урьдчилсан мэдээгээр нийт дүүргийн төсвийн орлогын 84.8 тэрбум төгрөгийг (80.2%) тусламжийн орлого буюу улсын төсвийн санхүүжилт, 20.1 тэрбум төгрөгийг (19%) татварын орлого, 0.8 тэрбум төгрөгийг (0.8%) татварын бус орлого тус тус эзэлж байна. Төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 24.6 тэрбум төгрөгөөр (18.9%) дутуу бүрдсэн байна. Үүнд татварын орлого 12.2 тэрбум төгрөгөөр (37.7%) дутуу бүрдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 7. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 13. Төсвийн орлогын гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%	Зөрүү
Нийт орлогын дүн	130 493.7	105 889.1	81.1	-24 604.6
Тусламжийн орлого ²	96 561.4	84 892.3	87.9	-11 669.1
Тусгай зориулалттай шилжүүлгээс	95 789.0	84 335.2	88.0	-11 453.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	772.4	557.1	72.1	-215.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих ¹	33 932.3	20 996.8	61.9	-12 935.5
Татварын орлого	32 340.6	20 148.7	62.3	-12 191.9
Татварын бус орлого	1 591.7	848.1	53.3	-743.6

Хүснэгт 14. Татварын орлогын бүрдүүлэлт, сая төгрөг

Үзүүлэлт	2020 он			
	Нийт төсөв	Өссөн дүн (эхний VII сард)		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувийн жин
Татварын орлого	48 676.4	32 340.6	20 148.7	62.3
Орлогын албан татвар	29 470.7	19 491.3	15 137.3	77.7
Хувь хүний орлогын албан татвар	29 470.7	19 491.3	15 137.3	77.7
Үйл ажиллагааны орлого	3 610.7	2 158.0	3 761.5	174.3
Хөрөнгийн орлого	15 700.0	10 658.3	7 389.0	69.3
Хөрөнгө борлуулсны орлого	4 100.0	2 621.7	826.5	31.5
Шууд бус орлого	6 060.0	4 053.3	3 160.3	78.0
Хөрөнгийн албан татвар	115.7	53.1	43.5	81.9
Бууны албан татвар	115.7	53.1	43.5	81.9
Бусад татвар, төлбөр, хураамж	19 090.0	12 796.2	4 967.9	38.8
Улсын тэмдэгтийн хураамж	3 400.0	2 182.7	2 073.5	95.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4 290.0	2 685.5	1 995.9	74.3
Газрын төлбөр	11 400.0	7 928.0	891.1	11.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	2.3	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.0	0.0	5.1	0.0

Төсвийн зарлага: 2020 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлийн мэдээгээр дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 76.0 хувийг (101.8 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 24.0 хувийг (32.2 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

¹ Орон нутгийн төсвөөс санхүүжих дүнд урьд оны үлдэгдлээс санхүүжих дүн ороогүй.

² Тусгай зориулалттай шилжүүлэгийн орлогод төсвөөс санхүүжих дүн, хандив тусламжийн орлогыг оруулсан.


Хүснэгт 15. Төсвийн зарлагын гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%	Зөрүү
Нийт зардлын дүн	133 997.9	101 793.1	76.0	-32 204.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	47 479.9	40 935.4	86.2	-6 544.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5 688.4	4 994.2	87.8	-694.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 220.8	2 980.6	57.1	-2 240.2
Хангамж бараа материалын зардал	7 953.0	5 320.9	66.9	-2 632.1
Нормативт зардал	3 785.3	3 140.7	83.0	-644.6
Эд, хогшил урсгал засварын зардал	1 217.4	1 036.3	85.1	-181.1
Томилолт зочны зардал	17.0	17.0	100.0	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4 038.4	3 082.3	76.3	-956.1
Бараа үйлчилгээний бусад зардал	6 022.0	5 332.8	88.6	-689.2
Татаас	7 660.7	6 901.8	90.1	-758.9
Урсгал шилжүүлэг	38 203.3	24 333.9	63.7	-13 869.4
Хөрөнгийн зардал	6 711.7	3 717.2	55.4	-2 994.5

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн сарын мэдээ

Төсвийн зарлагыг бүтцээр нь авч үзвэл 40.2 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 4.9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлөх шимтгэл, 6.8 хувийг татаас, 23.9 хувийг урсгал шилжүүлэг, 24.2 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна. Дүүргийн төсвийн зардал нэмэгдэхэд урсгал шилжүүлгийн зардал голлох нөлөө үзүүлсэн бөгөөд 4, 5 дугаар сард сангийн яамнаас сургуулийн үдийн хоолны төсөв татсантай холбоотойгоор зардал нэмэгдсэн байна.

Зураг 8. Төсвийн нийт орлого, зарлага, сая төгрөг



³ Төсвийн орлого, зарлагыг Зураг 8-д 2020 оны 2 сард эхний 1,2 сарын гүйцэтгэлийг өссөн дүнгээр оруулсан.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


2020 оны 7 дугаар сард хэрэглээний үнийн индекс 2019 оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар өссөн ба 2019 оны эцэстэй харьцуулахад 3.8 хувиар өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 16. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020 VII</u> 2019 VII	<u>2020 VII</u> 2019 XII	<u>2020 VII</u> 2020 VI
Ерөнхий индекс	103.2	103.8	100.7
Хүнсний бараа, ундаа ус	107.0	114.3	102.0
Согтууруулах ундаа, тамхи	105.2	104.4	100.1
Хувцас, гутал, бөс бараа	103.9	100.9	100.1
Орон сууц, ус, түлш, цахилгаан	102.8	101.4	100.2
Гэр ахуйн бараа, тавилга	103.0	101.1	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.9	101.9	100.2
Тээвэр	93.6	93.8	100.9
Холбооны үйлчилгээ	100.2	100.1	100.1
Амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.1	99.8	100.0
Боловсрол	107.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	107.6	104.4	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.7	101.7	100.2

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.2 хувь, хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ 3.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 3.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 2.9 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 7.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 7.6 хувь ба бусад бараа үйлчилгээний үнэ 4.7 хувиар өссөн ба тээврийн үнэ 6.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 1.9 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Зураг 9. Хүнсний ногооны дундаж үнэ, төрлөөр, 2019, 2020 оны VII сард



Зураг 10. Махны үнэ, төрлөөр, төгрөгөөр



Хүснэгт 17. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаалагдаж буй түлш, шатахууны үнэ

Үзүүлэлт	2018 VII	2019 VII	2020 VII
	төгрөг		
Түлш:			
Хар мод	3 000	3 500	4 000
Нарс	3 000	3 000	3 500
Боловсруулсан нүүрс (шуудай)	-	4000	3 750
Шатахуун:			
АИ-95	2 120	2 240	1 900
АИ-76, 80	1 690	1 750	1 350
АИ-92, 93	1 800	1 830	1 400
Дизельтүлш	2 100	2 370	1 990
Газ	1 000	1 300	1 300

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ хуулийн дагуу 5 дугаар сарын 15ны өдрөөс нүүрс борлуулахыг хориглосон.

Хүснэгт 18. Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ, оноор

Нэр, төрөл	Хэмжих нэгж	2016 VII	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII
		төгрөг				
Гурил, дээд зэрэг, “Алтан тариа”ХК	кг	1 300	1 300	1 354	1 438	1 456
Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	1 150	1 000	1 050	1 094	1 160
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК	кг	900	900	860	862	890
Талх, “Атар”, “Талх чихэр	кг	1 200	1 200	1 170	1 272	1 274
Цагаан будаа, кг, задгай	кг	2 200	3 500	3 400	3 580	3 840
Шар будаа	кг	1 600	1 300	2 000	2 315	2 283
Хонины мах	кг	5 500	6 500	6 760	9 428	9 740
Үхрийн мах	кг	7 000	7 000	9 120	11 706	12 016
Адууны мах	кг	5 500	5 700	6 650	10 150	10 750
Сүү, задгай	литр	1 000	1 800	1 660	1 720	1 840
Сүү, савласан, “Элекстер”	0.5 литр	1 000	1 100	1 100	1 130	1 174
Төмс, дотоод	кг	1 000	700	1 560	1 150	1 748
Лууван, дотоод	кг	2 700	800	2 520	1 456	1 936
Манжин, дотоод	кг	4 000	1 000	3 270	1 794	1 956
Байцаа, дотоод	кг	1 000	1 500	1 740	2 286	2 174
Сонгино, хятад	кг	1 350	1 400	1 400	2 040	1 596
Элсэн чихэр, ОХУ	кг	2 300	3 300	3 000	3 146	3 072
Өндөг	ширхэг	280	350	350	365	365



АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн салбар нь 2020 оны эхний 7 сард 504.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 552.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйлдвэрлэлт 162.7 тэрбум төгрөгөөр (24.4%), борлуулалт 221.0 тэрбум төгрөгөөр (28.6%) тус тус

буурсан байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 190.8 тэрбум төгрөгийг (37.8%) уул уурхайн салбарын чулуун нүүрс болон хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, алт, элс, хайрга, шороо үйлдвэрлэл, 197.0 тэрбум төгрөгийг (39.1%) хүнс ундаа, 65.1 тэрбум төгрөгийг (12.9%) хувцас, гутал, нэхмэл, ноос, ноолуур боловсруулах болон бусад боловсруулах үйлдвэрлэлт, 12.6 тэрбум төгрөгийг (2.5%) цахилгаан, хий, уур, агааржуулалт үлдсэн 38.7 тэрбум төгрөгийг (7.7%) бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа тус тус эзэлж байна.

Зураг 11. Аж үйлдвэрийн 2019-2020 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөнд хүнсний үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад, цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл, ус ариутгал, усан хангамжийн үйлдвэрлэлт нөлөө үзүүлж байгаа ч хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах, хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээнүүдийг тус тус нэмж хамруулснаас шалтгаалан өссөн байна.

Хүснэгт 19. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр

Салбар	Нийт үйлдвэрлэлт		
	2019	2020	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт дүн	667 032.8	504 276.4	-162 756.4
Уул уурхай олборлох үйлдвэр	353 193.2	190 837.9	-162 355.3
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	313 441.2	145 753.7	-167 687.5
Металлын хүдэр олборлолт	21 218.4	19 539.7	-1 678.6
Бусад ашигт малтмал олборлолт	18 533.6	25 544.4	7 010.8
Боловсруулах үйлдвэр	274 927.7	262 092.3	-12 835.3
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	25 427.8	46 156.5	20 728.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	14 760.0	36 706.7	21 946.7
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	2 298.5	3 145.9	847.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 369.3	6 303.9	-2 065.4
Ундаа үйлдвэрлэл	146 633.5	150 838.2	4 204.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	87 465.7	42 396.9	-45 068.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4 607.3	1 760.3	-2 846.9
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	499.7	319.3	- 180.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	1 477.3	1 477.3
Нийтлэх, хэвлэх, дүү бичлэг хийх ажиллагаа	2 041.5	104.5	-1 937.0
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	85.1	11 311.1	11 226.0
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	1 246.6	1 621.4	374.8
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	593.9	1 889.8	1 296.0
Металл боловсруулах үйлдвэрлэл	1 278.1	41.9	-1 236.2
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	121.1	20.9	- 100.1
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	185.4	45.5	- 139.9
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	4 032.5	3 612.7	- 419.8
Бусад боловсруулах үйлдвэрлэл	709.5	495.9	- 213.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 060.2	12 620.6	11 560.4
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	37 851.8	38 725.7	873.9

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт, салбараар, оны үнээр

Салбар	Нийт борлуулалт		
	2019	2020	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт дүн	773 659.6	552 738.6	-220 921.0
Уул уурхай олборлох үйлдвэр	364 583.1	188 779.4	-175 803.7
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	314 805.7	145 753.7	-169 052.0
Металлын хүдэр олборлолт	21 218.4	19 539.7	-1 678.6
Бусад ашигт малтмал олборлолт	28 559.1	23 486.0	-5 073.1
Боловсруулах үйлдвэр	368 808.9	311 301.2	-57 507.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	51 553.7	51 332.9	- 220.8
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	37 982.6	36 761.7	-1 220.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	3 749.1	5 963.3	2 214.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 822.0	8 608.0	-1 214.0
Ундаа үйлдвэрлэл	211 564.2	197 439.4	-14 124.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	87 465.7	42 396.9	-45 068.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4 608.2	1 764.3	-2 843.9
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	478.4	268.9	- 209.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	1 505.1	1 505.1
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	2 039.5	89.2	-1 950.3
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	93.1	8 737.4	8 644.4
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	3 130.1	1 621.4	-1 508.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	613.9	2 026.9	1 413.1
Металл боловсруулах үйлдвэрлэл	1 331.5	41.9	-1 289.6
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	121.1	20.9	- 100.1
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	185.4	19.7	- 165.7
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	4 832.1	3 612.7	-1 219.4
Бусад боловсруулах үйлдвэрлэл	792.2	423.3	- 368.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 056.8	12 620.6	11 563.7
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	39 210.7	40 037.4	826.6

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network




www.facebook.com/StatisticMongolia/




www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

Утас: 267349, 261019, 261728
E-mail: bayanzurkh@nso.mn